



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/115/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд хот

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас:70523020

Цахим хаяг: [DORNOGOVI@AUDIT.COM](mailto:DORNOGOVI@AUDIT.COM)

Ц.Лүндэгмаа

Цахим хаяг: [Lundegmaa.ts@audit.gov.mn](mailto:Lundegmaa.ts@audit.gov.mn)

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗАА	Захирагчийн ажлын алба

## Агуулга

---

1	Аудитын тайлан .....	5
2.1.	Оршил .....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
2	Менежментийн захидал .....	11

## 1 Аудитын гэрчилгээ



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2019.02.25 № 1-6/168

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД  
СУМЫН ЗҮҮНБАЯН БАГИЙН  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА З.ГАНЗОРИГ ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнбаян багийн Захирагчийн ажлын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Зүүнбаян багийн Захирагчийн ажлын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зүүнбаян багийн Захирагчийн ажлын албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Сайншанд сумын Зүүнбаян багийн Захирагчийн ажлын алба нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Багийн засаг дарга Ц.Ганзоригт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019-01-15-наас 2019-01-17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019-01-17-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцан хэрэгжүүлэв.

Сайншанд сумын Зүүнбаян багийн ЗДТГ-ын ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019-02-12-ны өдрийн №1/115 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.



### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Сайншанд сумын Зүүнбаян багийн ЗДТГ-ын ажлын алба нь “Төр эдийн засаг, нийгмийн бодлогын үйл ажиллагаа” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сайншанд сумын Зүүнбаян багийн ЗДТГ-ын ажлын алба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.



## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгөөс материаллаг байдлын түвшинг тогтооход өндөр гарч байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг түвшинг тогтоов.

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба 2018 оны нийт зардал 1,643.60 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1,643.60 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцов.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	8,000.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	5,861.4	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	

5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00
	Дүн	0	13,861.4

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### 2.8.2 Зардлын данстай холбоотой

Тайлант оны эцэст нийт 5,861.5 мянган төгрөгийн төсвийн зардлын хэмнэлтийг илүү шилжүүлэн санхүүгийн тайланд авлага үүсгэн бүртгэсэн байна. Тухайлбал:

- Цэвэр бохир усны зардлаас 280.7 мянган төгрөгийг Чандмань Илч ХХК;
- Цалингийн зардлаас 2,915.8 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын хэлтэс;
- Цалингийн зардлаас 2,652.7 мянган төгрөгийг Татварын хэлтсийн дансанд тус тус шилжүүлжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, 39 дүгээр зүйлийн 39.4.2-д “өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Илүү шилжүүлсэн 5,861.5 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 2.8.3 Бараа материалын тайлантай холбоотой

НББ-ээр 113.5 мянган төгрөгийн шатахууныг зарлагдаагүй үлдэгдлээр тайлагнасан байна.

**Шийдвэрлэсэн:** Аудитын явцад алдааг санхүүгийн тайланд залруулав.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 131,310.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 128,538.9 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь халагдсан болон ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын цалингийн зардал нийт 2.8 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

#### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Сайншанд сумын Зүүнбаян багийн ЗДТГ-ын ажлын алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

#### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг ирүүлээгүй байна.

#### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Сайншанд сумын Зүүнбаян багийн захирагчийн ажлын алба нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **2.1 Хандив, тусламжийн данстай холбоотой**

##### 2.1.1 Илрүүлэлт

Тус байгууллагад Арьвамайнз ХХК нь 4 ширхэг худаг засварлах ажлыг гүйцэтгэхэд 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлжээ. Гэрээний биелэлтийг дүгнээгүйгээс худгийн ажил бүрэн гүйцэд хийгдсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

##### 2.1.2 Өгсөн зөвлөмж

Төсөл хөтөлбөр, хандив тусламжаар хийгдсэн ажлын гэрээг дүгнэж, гэрээний биелэлтийг ханган ажиллах.

***Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 12 сарын 25-ны дотор ирүүлнэ үү.***

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7638689.81</b>	<b>8108946.37</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3781989.81</b>	<b>5861466.37</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2540.57	
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>3779449.24</b>	<b>5861466.37</b>
3351	Байгууллагаас авах авлага	3779449.24	581466.37
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3856700,00</b>	<b>2247480,00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>3856700,00</b>	<b>2247480,00</b>
35410	Бичиг хэргийн материал	131500,00	131800,00
35420	Аж ахуйн материал	2115680,00	2115680,00
35440	Түлш, шатах тослох материал	1609520,00	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>155423914.94</b>	<b>170330372.71</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>155423914.94</b>	<b>170330372.71</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>154159414.94</b>	<b>151343372.71</b>
39201	Барилга, байгууламж	253180832,00	207302105,88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-162246620,67	-111517757,06
39203	Авто тээврийн хэрэгсэл	9790000,00	9790000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6494000,04	8452000,08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47352170	49377170
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12430470.07	-18247057.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25257790	25257790
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5921579.72	-8672148.44
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1264500,00</b>	<b>18987000,00</b>
39301	Програм хангамж	1264500,00	1264500,00
39302	Хуримтлагдсан элэгдэл		421500,00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>163062604.75</b>	<b>178439319.08</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>448411.50</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		448411.50
<b>413</b>	<b>Өглөг</b>		448411.50
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>163062604.75</b>	<b>177990907.58</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>163062604.75</b>	<b>177990907.58</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>24656473.13</b>	<b>4829889.64</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	24656473.12	24656473.12
51220	Тайлант үеийн үр дүн		-19826583.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>163062604.75</b>	<b>178439319.08</b>

### 3.2 АУДИТ ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>134337922.00</b>	<b>144765100.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>102569922.00</b>	<b>142740100.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>39922522.00</b>	<b>11429800.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>62647400.00</b>	<b>131310300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62647400.00	131310300.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>101654417.53</b>	<b>156619800.75</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>101654417.53</b>	<b>156619800.75</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	101654417.53	153848400.75
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>47585502.48</b>	<b>96734854.10</b>
210101	Үндсэн цалин	42072438.48	88433907.00
210105	Гэрээтийн цалин	5513064,00	8300947,10
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5560123.80</b>	<b>11756305,34</b>
210201	Тэтгэврийн даатгал	5560123,80	8711814,07
210202	Тэтгэмжийн даатгал		761148,73
210203	ҮОМШӨ-ний даатгал		608417,96
210204	Ажилгүйдлийн даатгал		152229,80
210205	Эрүүл мэндийн даатгал		1522294,78
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5856408,00</b>	<b>10903196,00</b>
210301	Гэрэл, цахилгаан	398364,00	1004455,00
210302	Түлш, халаалт	4991957,00	8516492,00
210303	Цэвэр, бохир усны зардал	466087,00	1382249,00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3662593,30</b>	<b>10210831,50</b>
210401	Бичиг хэрэг	863020,00	1538700,00
210402	Тээвэр, шатахуун	1273146,80	4208720,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1411866,50	2848411,50
210406	Бага үнэ түргэн элэгдэх	114560,00	1615000,00
	<b>Нормативт зардал</b>	<b>382015,00</b>	<b>1322600,00</b>
210502	Хоол	382015,00	1322600,00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1500000,00</b>	<b>8500000,00</b>
210604	Урсгал засвар	1500000,00	8500000,00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1505400,00</b>	
210702	Дотоод албан томилолт	1505400,00	
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	29418217,00	519068,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29418217,00	519068,00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6184157,95</b>	<b>13901545,81</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6184157,95	13901545,81
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>2771400,00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2771400,00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		2771400,00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>32683504,47</b>	<b>-11854700,75</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>32683504,47</b>	<b>-19826583,48</b>



3.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	144256922,00	141740100,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200000,00	
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	144056922,00	142740100,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39922522,00	11429800,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	104134400,00	131310300,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104134400,00	131310300,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	143841257,27	142740100,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	143841257,27	142740100,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	143841257,27	139968700,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	80194602,77	97560636,31
210101	Үндсэн цалин	68886087,55	85911129,53
210105	Гэрээтийн цалин	11308515,22	11649506,78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9943800,00	12729295,69
210201	Тэтгэврийн даатгал	9943800,00	8325395,69
210202	Тэтгэмжийн даатгал		1101000,00
210203	ҮОМШӨ-ний даатгал		819863,20
210204	Ажилгүйдлийн даатгал		281036,80
210205	Эрүүл мэндийн даатгал		2202000,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6511862,00	12093900,00
210301	Гэрэл, цахилгаан	761074,00	1004455,00
210302	Түлш, халаалт	5127957,00	9426492,00
210303	Цэвэр, бохир усны зардал	622831,00	1662953,00
2104	Хангамж, бараа материалын зардал	8668070,50	7243200,00
210401	Бичиг хэрэг	1133220,00	1534000,00
210402	Тээвэр, шатахуун	4334580,00	2609200,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2652710,50	2400000,00
210404	Ном, хэвлэл	44000,00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	503560,00	700000,00
	Нормативт зардал	5799305,00	1322600,00
210502	Хоол хүнс	4954305,00	1322600,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	845000,00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1500000,00	8500000,00
210604	Урсгал засвар	1500000,00	8500000,00
2107	Томилолт, зочны зардал	1505400,00	
210702	Дотоод албан томилолт	1505400,00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29718217,00	519068,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29718217,00	299068,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		220000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2771400,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	415664,73	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	150000,00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
2200	Дотоод эх үүсвэрээр	150000,00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	150000,00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-150000,00	
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	265664,73	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	265664,73	00.00

3.4 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	138406131,63	00,00	-5374074,42	133032057,21
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>138406131,63</b>	<b>00,00</b>	<b>-5374074,42</b>	<b>133032057,21</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	32683504,47	32683504,47
C08	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>138406131,63</b>	<b>00,00</b>	<b>24656473,12</b>	<b>163062604,75</b>
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>138406131,63</b>	<b>00,00</b>	<b>24656473,12</b>	<b>163062604,75</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>138406131,63</b>	<b>00,00</b>	<b>24656473,12</b>	<b>163062604,75</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	16610886,31	00.00	16610886,31
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	18144000,00	00.00	-19826583,48	-1682583,48
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>156550131,63</b>	<b>16610886,31</b>	<b>4829889,64</b>	<b>177990907,58</b>

3.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	131,310,300.00	128,538,900.00	2,771,400.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	131,310,300.00	128,538,900.00	2,771,400.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	131,310,300.00	128,538,900.00	2,771,400.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	99,808,600.00	97,560,636.31	2,247,963.69
210101	Үндсэн цалин	75,328,600.00	85,911,129.53	-10,582,529.53
210105	Гэрээт ажлын хөлс	24,480,000.00	11,649,506.78	12,830,493.22
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,211,800.00	12,729,295.69	482,504.31
210201	Тэтгэврийн даатгал	8,407,600.00	8,325,395.69	82,204.31
210202	Тэтгэмжийн даатгал	960,600.00	1,101,000.00	-140,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,201,900.00	819,863.20	382,036.80
210204	Ажилгүйдлийн даатгал	241,300.00	281,036.80	-39,736.80
210205	Эрүүл мэндийн даатгал	2,400,400.00	2,202,000.00	198,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,183,900.00	11,183,900.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	800,000.00	1,004,455.00	-204,455.00
210302	Түлш, халаалт	9,000,500.00	8,516,492.00	484,008.00
210303	Цэвэр, бохир ус	1,383,400.00	1,662,953.00	-279,553.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,086,000.00	6,046,000.00	40,000.00
210401	Бичиг хэрэг	1,574,000.00	1,534,000.00	40,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,412,000.00	1,412,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,400,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,000.00	700,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	500,000.00	0.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	520,000.00	519,068.00	932.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	299,068.00	932.00
210803	Даатгалын үйлчилгээ	20,000.00	00.00	20,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	00.00	180,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	220,000.00	-200,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	131,310,300.00	128,538,900.00	0.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	0.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	00.00	00.00	0.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	00.00	00.00	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00	0.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	00.00	0.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	131,310,300.00	128,538,900.00	00.0
132001	Орон нутгийн төсвөөс	131,310,300.00	128,538,900.00	00.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	00.00	00.00	0.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	00.00	00.00	0.00
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00	0.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00	0.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	18.00	18.00	0.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	0.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	0.00